



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 551

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсролын үнэлгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 246,300,890.00 (хоёр зуун дөчин зургаан сая гурван зуун мянга найман зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн
...57 дугаар тогтоолын хавсралт

Боловсролын үнэлгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, балансаас балансад шилжүүлэх
эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Хэмжээ нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан нэгдэл	Үлдэгдэл өртөг
					нэг бүрийн энэ	нийт үнэ (төгрөгөөр)		
1	Бичгийн ширээ (1600*800*750)	ш	10	2013/12/27	787,040.00	7,870,400.00	-	7,870,400.00
2	Номын шүүгээ	ш	10	2013/12/27	655,040.00	6,550,400.00	-	6,550,400.00
3	Номын шүүгээний ком	ш	10	2013/12/27	1,104,000.00	11,040,000.00	-	11,040,000.00
4	Номын шүүгээ (модон хаалгатай)	ш	24	2013/12/27	380,040.00	9,120,960.00	-	9,120,960.00
5	Хувцасаны шкаф	ш	24	2013/12/27	655,040.00	15,720,960.00	-	15,720,960.00
6	Шүүгээ (ширээний дэргэд байрлах)	ш	31	2013/12/27	398,750.00	12,361,250.00	-	12,361,250.00
7	Шүүгээ (ширээний хажуу талын татаж онгойлгодог)	ш	38	2013/12/27	273,340.00	10,386,920.00	-	10,386,920.00
8	Ширээ	ш	10	2014/12/31	190,000.00	1,900,000.00	-	1,900,000.00
9	Ширээ (сургалтын өргөн)	ш	10	2010/06/20	135,000.00	1,350,000.00	-	1,350,000.00
10	Хэвлэлийн машин	ш	1	2016/10/05	170,000,000.00	170,000,000.00	-	170,000,000.00
НИЙТ ДҮН			168			246,300,890.00	-	246,300,890.00
						(хоёр зуун дөчин зургаан сая гурван зуун мянга найман зуун ерэн)	(хоёр зуун дөчин зургаан сая гурван зуун мянга найман зуун ерэн)	